

АГВААНДАНДАР ЛХАРАМБЫН НАМТРЫН ТОВЧООН

Г. Лувсанжамц - МУИС. НШУС. Шашин Судлалын тэнхим, докторант

Түлхүүр үг: Агваандандар лхарамба, Хэ Чоймбол, Ван Мандуга, лондол лам Агваанлуvsан, Алшаа.

Өгүүллийн товч утга: ХҮИИ зууны монголын тэргүүний гүн ухаантнуудын нэг Алшаа лхарамба Агваандандарын намтар бүтээлийн тухай энэ өгүүллэгт бичив. Ингэхийн сацуу Агваандандар лхарамбын талаарх судалгааны тоймыг хавсран гаргасан болно.

Эрхэм таны зохист аялгууны чандмань алины хариуд Эгэл миний үгэн хэлхээс хөвөрдсөн атгагдас эгүүнийг Эрхт мэргэдэд бишрэлийн бэлгэнд өргөх нь бэрх боловч Эрхгүй санаанд орсныг мугуйдлан энэ мэтийг айлтгаваа “Цандог Номун хаанд өргөсөн айтгал бичиг”-ээс

Алшаагийн Агваандандар лхарамбын намтарыг хуучин Төвд Монголын уламжлалт намтар бичлэгийн ёсны дагуу тусгайлан бичсэн нь байдаггүй. Өвөр Монголын эрдэмтэн Төвжаргалын бичсэнээр “Агваандандар лхарамбын данраг” гэж нэгэн төвд намтар Алшаагийн Зүүн сүмд хадгалагддаг байсан нь Соёлын хувьсгалын үед устаж үгүй болсон ажээ.¹ Гэвч түүний намтартай холбоотой нилээд олон аман ярианы зүйлүүд монгол, төвд лам хуврагуудын дунд өргөнөөр уламжлагдан яригдсаар ирсэн байдаг. Сүүлийн үеийн судлаач эрдэмтэдийн хийсэн судалгаа шинжилгээний ажлыг үндэс болгох бөгөөс Алшаа лхарамба Агваандандар нийтийн он тоололын 1759 он буюу билгийн тоололын ёсоор арван гуравдугаар жарны шарагчин туулай жил Алшаагийн Хошууд хошууны² Зүүн сумны Баяннуруу багын нутагт Их Хойд овгийн Үйзэн зайсан Инайн хоёрдугаар хүү болон мэндэлсэн байна.³

Хе Чоймбол, Ван Мандауга, М.С. Өлзий, Оюун тэргүүтэн Өвөр Монголын судлаачдынхаар европын тооллын 1758 онд төрсөн гэсэн байх боловч Агваандандар лхарамбын өөрийн зохиол бүтээлүүдийн төгсгөлийн үгэнд хэдэн настайдаа хэдийд хаана бичсэнээ тодорхой бичсэнээс хөөн үзэхэд чухам хэдэн онд төрсөнийг баталгаатай гаргаж болох юм. Энд жишээ болгоход *Шүтэн барилдлагын магтаалын бэрх орноос үүдсэн утгын тайлбар Эрдэнийн эрхи* хэмээх зохиолынхоо төгсгөлийн үгэнд “...Алшаа молом равжамба Агваандандар хэмээгч бээр далан гурван настайдаа арван дөрөвдүгээр жарны цагаагчин туулай жилийн монголын хоёрдугаар сарын шинийн гурванд найруулсаны бичээч нь гэлэн Цүлтимравян болой.” гэснээс үзэхэд 14-р жарны цагаагчин туулай жил бол европын 1831 онтой харгаж байна. 1831 оноос тухайн жилийн нас 73-ыг хасахад 1758 он гарах боловч хий нас тооцдог монголын уламжлалаар авч үзэх бөгөөс европын тоололын 1759 онд төрсөн байх учиртай юм. Мөн 1831 онд 73-ны жил нь орж байснаас

Агваандандар-ун судуулан-у огулел-ун цууулан, Агваандандар-ун судулул-ун цубурал бициг, Обөр Монгол-ун сойол-ун кеблел-ун огуу-а, Цайлар Цота, 1999 (49-р хуудас)

Ван Мандауга (ibid. 87-р хуудас) Өөлд хошуунд төрсөн гэж бичсэн байна. Агваандандар лхарамбын төрсөн нутаг нь

одоогийн БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Алшаа аймгийн Зүүн хошуунд хамрагдана

Агваандандар-ун судуулан-у огулел-ун цууулан, Агваандандар-ун судулул-ун цубурал бициг, Обөр Монгол-ун сойол-ун кеблел-ун огуу-а, Цайлар Цота, 1999

үзэхэд 1759 оны туулай жил төрсөн нь батлагдаж байна. Гэвч Өвөр Монголын судлаач Г. Цогт¹ шарагчин туулай жилийн өвөл төрсөн гэж тэмдэглэсэн байгаагаар авч үзэх юм бол 1760 оны өвөл буюу шарагчин туулай жилийн сүүлчээр ч төрсөн байж болох талтайг анхаарууштай юм.

Түүнчилэн Хе Чоймбол, Ван Мандауга, Оюун нарын судлаачид Тэнгэр тэтгэгчийн 23-р онд төрсөн гэсэн мэдээлэл дээр үндэслэн 1758 оныг баримталсан бололтой боловч яг ямар эх сурвалжийг үндэс болгосноо дурдаагүй байна. Төвжаргал Тэнгэр тэтгэгчийн 24-р он буюу 1759 оны шарагчин туулай жил төрсөн гэсэн бол Өлзий гуай Тэнгэр тэтгэгчийн 23-р он, нийтийн тоололын 1759 оны шарагчин туулай жил төрсөн гэж тэмдэглэсэн байна.

Агваандандар лхарамбыг 7 настай байхад нь эцэг эх нь лам хувраг болгохоор шийдэж, хошууныхаа Буяныг Аривтгагч хийдэд шавилан суулгаснаар эрдэм номын энгүй их харгуйд хөл тавьж, төвд, монгол бичиг үсэг хийгээд бурханы шашины анхан шатны боловсролыг олжээ. Тэрээр 19 нас хүртлээ хийдийнхээ Цанид дацангийн хуврагуудын эгнээнд суун цанидын ном үзэж, чойрын таван ботд суралцсан гэдэг.² Уг хийдэд сууж байхдаа чухам ямар ямар багшийг шүтэж ном үзсэн тухай тусгайлан тэмдэглэсэн мэдээлэл байхгүй бөгөөд Төвжаргалын тэмдэглэснээр нутгийнхаа сүмийн нэгэн эрдэмтэй "... эцэг эх нь шавь болгон өгснөөр "...багшийнхаа ном сургаалыг хичээнгүйлэн сонсч, төвд номыг сайтар чармайн сурсан бөгөөд бас монгол хэл бичгийг дагалдан сурдаг байжээ".³ Түүнчилэн Ван Мандауга Агваандандар лхарамбыг нутгийнхаа өөр нэгэн сүм болох Буяныг Үндэслэгч сүмийн "Ухааны орныг сурах салбар"⁴-т орж суралцав гэж бичсэн байдаг.⁵

Улмаар тухайн үеийн Алшаагийн сүм хийдүүдийн шашин номын сургуулийн дүрэм заншил ёсоор⁶ 1776 онд 19 настай байхдаа хийдийнхээ Чоомдой багш лам⁷, жич хошуу яамны ноёдын дэмжлэгтэйгээр Амдогийн Гонлүн болон Гүнбүм хийдүүдээр дамжин Төвд орох замдаа Гонлүн⁸ хийдэд Дээд Монголын алдарт эрдэмтэн Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788)-т шавь орж нэг жил шахам суусан байна. Цааш Лхасын Бэрээвэн хийдийн Гомон дацанд очиж таван ухаанд нэвтэрхий шалгарсан Лондол лам Агваанлуvsан (1711-1795)-ыг голлон шүтэж хорин дөрвөн жилийн турш хатуужилтайгаар бэрхшээл бүхнийг даван туулж, Гүнчэн игчааны⁹ ёсоор цанид чойрын таван ботийг хичээнгүйлэн сурсаны эцэст Лхасын цагаан сарын их ерөөлөөр¹⁰ лхарамбын дамжаа барьж олонд нэр алдар нь дуурьссан их эрдэмтэн болжээ.

Лондол ламаас гэлэн сахил хүртэж сахилын нэр нь Агваандандар гэдэг болсноор энэ нэрээрээ алдаршсан байна.¹¹ *Аврал одуулахын ёсоос үүдсэн цадиг есөн хүслийг хангагч*

¹ Ayvandandar-un sudulyan-u ögülei-un çiyulyan, Ayvandandar-un sudulul-un çubural biçig, Obör Mongyol-un soyol-un keblel-un qoriy-a, Qayilar Qota, 1999 (79-p хуудас)

² Alъa merged-un çiyulyan, Oyirad surbalji biçig-un san, Alъa ayimag-un ulus toru-yin jöblelgen-u keblülge, 1990 (2-p хуудас)

³ Ayvandandar-un sudulyan-u ögülei-un çiyulyan, Ayvandandar-un sudulul-un çubural biçig, Obör Mongyol-un soyol-un keblel-un qoriy-a, Qayilar Qota, 1999 (35-p хуудас)

⁴ Ригнай дацан гэхийг ингэж орчуулсан байж магадгүй

⁵ Ayvandandar-un sudulyan-u ögülei-un çiyulyan, Ayvandandar-un sudulul-un çubural biçig, Obör Mongyol-un soyol-un keblel-un qoriy-a, Qayilar Qota, 1999 (68-p хуудас)

⁶ Alъa merged-un çiyulyan, Oyirad surbalji biçig-un san, Alъa ayimag-un ulus toru-yin jöblelgen-u keblülge, 1990 (2-p хуудас)

⁷ Энэ мэдээгээр бол түүний нутгийнхаа хийдэд шавилан сууж байх үеийн гол багш нь энэ лам байсан байж магадгүй.

⁸ Гонлүнжамбаалин хийд бол Амдогийн уулархаг нутагт Гүнбүм хийдээс баруун ургашаа оршдог Сүмба хамба Ишбалжир.

⁹ Туган гэгээн Чойжижанцан, Жанжаа Агваанчойзин нарын ихэс дээдэс нарын сууж байсан гэлүгба есны томоохон хийд юм. Лхасын Гомон хийд. Их Хүрээнийн Дашчойнбол дацан зэрэг Төвд, Монголын олон хийдүүдийн лам нарын гүн ухаанд суралцах үндсэн чиглэл болдог.

¹⁰ Лхаса молон ч гэдэг. Цагаан сарын шинийн 8-наас 15 хүртэл Лхасын Их Зуугийн дуганд Төвдийн гурван их хийд Сэра, Бэрээвэн, Гандангийн лам хуврагууд Бурхан багшийн рид хувилгааныг үзүүлсэн их үйлсийг дурсан их ерөөл хурдаг бөгөөд энэ ерөөлийн үеэр гурван их хийдийн лам нарын дунд гавьжийн дамжаа барьсан хүнийг Лхасын молон равжамба буюу лхарамба гэдэг.

¹¹ Töbjirgal, Ayvandandar-un amidural ba jokiya butegel-un tuqai, Ayvandandar-un sudulyan-u ögülei-un çiyulyan, Ayvandandar-un sudulul-un çubural biçig, Obör Mongyol-un soyol-un keblel-un qoriy-a, Qayilar Qota, 1999 (38-p хуудас)

эрдэнийн сайн хумх хэмээх зохиолынхоо төгсгөлийн үгэнд ч "...анхдугаар хамбо бээр өөрийн сахилын хамбо Лондол лам Агваанлуvsанг хэлсэн ба Лондол лам түүнд анх сахил хүртээхдээ сахилын нэрийг хайрлах ёсны дагуу эгэлийн нэрийг номын нэрээр арилжин өөрийн алдраас Агваан гэсэн хэсгийг оруулсан Агваандандар гэдэг нэр өгсөнийг дурьдсан байна.

Лондол лам Агваанлуvsан ринбүүчийг өөрийн үндсэн багшаа болгон шүтдэг байсан бөгөөд багшдаа зориулсан чин сүжиг бишрэл нь түүний зохиол бүтээлүүдэд илэрсэн байдаг. "Шар малгайтны шашны гол шимийг эзэмшсэн, хоёрдугаар ялгуулсанаас (Богд Зонхава) ялгалгүй их бүтээлч эрдэмтэн..."¹, "янагуух үнэнийн номуудыг усанд туссан саран мэт болгоон үзэж, хамаг амьтныг гагц хүү шигээ хайрладаг, их нигүүлсэхүйн үүднээс хоёр зэргийн ёгад нэгэн үзүүрт сэтгэлээр шулуудсан агуу их бүхнийг тэвчигч, алдарыг нь өгүүлэхүйеэ бэрх, тэнцэшгүй зарлигын ачит богд, бүтээлийн эрх баялаг Лондол лам..."², "юмс үзэгдэлийг илбэ мэт болгоосон, өөрөөсөө илүүтэйд өвөр өвөр бусдыг энхрийлэн баригч их бодисадва"³ гэх мэтээр магтан бичсэн байхаас гадна Лондол лам Агваанлуvsанд зориулан зохист аялгууны гучин хоёр үлгэр чимгээр магтан бичсэн *Үлгэр чимгийн үүднээс ламыг магтсан Эрдэнийн далайд цутгагч сүсгийн мөрөн* хэмээх яруу найргийн бүтээлээ туурвисан байдаг. Монгол лам нарын дунд дэлгэрсэн аман яриагаар бол Дандар лхарамбыг Лхасын их ерөөлд лхарамбын дамжаа барихын өмнө Лондол лам түүнийг олон мэргэдийн өмнө даруу төлөв байдлыг барин дамжаа барихдаа бусдыг аль болох мохоохгүй байхыг захисаны дагуу дамжаа барьж байсан боловч зарим хүмүүс "Алшаа Дандарт сурсан юм гэж юу байдаг юм. Хайс⁴ нь хоосон юм чинь шанага нь дундуур л байж таараа даа"⁵ гэх мэтээр хорыг нь малтахад тэсэлгүй дагсал хаяж буй лам нарын гаргалгаа ухааныг тас няцааж бусдыг сүрхий мохоосон гэдэг бөгөөд дамжаа бариад багшдаа бараалхахад нь Лондол лам хожим хойшдын чинь үйлс барцад саадтай тааруухан хэрэг боллоо гэж зэмлэж байсан гэдэг.⁶

Наймдугаар Далай ламын багш Ёнзин Ишжалцан (1713-1793)-гаас нууц тарнийн увидас номыг олонтоо хүртэж, улмаар аграмбын дамжааг Лхасад байхдаа ч барьсан гэдэг.⁷

Агваандандарын эрдэм мэдлэгийн тухай яриа Төвд хийгээд Монгол даяар тархан алдаршихад энэ чимээ Алшаа вангийн сонорт хүрч, улмаар хошууны тамгийн газраас Буяныг Аривтгагч сүмийн даа ламын газарт тушааснаар нутаг хошуундаа буцаж ирэхийг тусгайлан заллага айлтган гуйжээ. Заллагыг хүлээн авмагч Агваандандар лхарамба Лхасын хийд дацангуудын сахиуснуудад мөргөж, лам багш нартаа бараалхан салах ёсыг гүйцэтгэх зуураа Лондол лам багшдаа бараалхан учир явдлаа айлтгахад багш нь "Чи урьд Лхасын их ерөөлөөр дамжаа барихдаа дээд арван газрыг олсон олон бодьсадваа нарын өөдөөс ширүүн хандсан учраас үйлс пэрэнлэй чинь муудсан тул нутагтаа хариад хожим егзүрийн⁸ явдалаар эгэл хар хүний дүрийг барьж амьдран амьтны тусыг үйлдэж, туслах

¹ Skyabs su 'gro ba' tshul las rtsam pa'i gtam 'dod dgu 'jo ba'i rin chen bum bzang (106a-p хуудас)
² Rgyud gzhan sgrub pa'i 'grel a mkhas pa'i yid 'phrog (21a-p хуудас)
³ Dpe rgyan gyi sgo nas bla ma la bstod pa yon tan rgya mtsor gzhol ba'i dad pa'i chu bo (4b-p хуудас)

⁴ Баруун Монголд тогоог хайс гэдэг
⁵ Багш нь эрдэмгүй тул шавь нь ч мэдлэггүй гэж тогоо болон шанагаар үлгэрлэн дайран хэлсэн байна

⁶ Үүнийг Гандантэгчэнлин хийдийн Дашчойнпэл дацангийн гэвш Баруун багш хэмээн алдаршсан Сэр-Од багшийн 1993 онд онд айлдсанаар бичлээ

⁷ Tobjirgal, Ayvandandar-un amidural ba jokiyal butegel-un tuqai, Ayvandandar-un sudulyan-u ögölel-un öiyulyan, Ayvandandar-un sudulul-un cūburai bičig, Obor Monγol-un soyol-un keblel-un qoriy-a, Qayilar Qota, 1999 (38 болон 40-р хуудасууд)

⁸ Егачара буюу тарнийн ёсны явдалаар амьдран Бурханы хутгийг олохыг хичээгч.

сургаал номыг зохиовоос сайн болно” хэмээгээд хойшид өөрөөс нь ирэх сураг чимээ хүлээхийг даалгасан гэдэг.¹

Гоман дацангийн Гүнчин игчааны дагуу чойрын таван ботид бүрэн суралцан лхарамбын дамжаа барихад 21 жил, аграмбын дамжаа барихад 2 жил суралцах хэрэгтэй бөгөөд нийт 23-24 жил зарцуулдагаас үзэхэд 1776 онд 19 настайдаа нутгаасаа гарч Гонлүн хийдэд 1 жил сураад 1777 онд Лхасад очиж, Гоман дацанд сууж эхлэсэнээс эхлэн тооцох бөгөөс 1801 оны орчимд 43 настайдаа бурханы шашины судар тарнийн ёсны боловсролын оргилд хүрсэн бололтой. Лхасын их ерөөлд дамжаа барьж лхарамба болсон тухайгаа өөрийн зохиол бүтээлүүддээ олонтаа дурдаж, Лхасын ерөөлийн равжамба², монрамба³, Лхасад даж эргүүлж дамжаа барьсан нэрт⁴ гэх мэтээр бичсэн байхаас гадна Хайдүе цоржсийн зохиосон “Их Богд өөр ямагтын магтаал Сүсгийн цэнгэлийн далай” хэмээхийн тайлбар Хүслийн цэнгэлийн далайд орох онгоц⁵ хэмээх зохиолынхоо төгсгөлийн үгэнд “Жамбалжамц Далай ламын (1758-1804) үед Лхасын их ерөөлд дамжаа барьсан Монгол үндэстэн Алшаа Агваандандар” гэсэн бол Аврал одуулахын ёсоос үүдсэн цадиг есөн хүслийг хангагч эрдэнийн сайн хумх⁶ хэмээх зохиолдоо “...таван их ботийг судалсаны үр дүнд цагаан дуазын дор дамжаа барьсны тэмдэг болгож Лхасын их ерөөлийн равжамба гэж дуудагддаг нэгэн...” гэх мэтээр сонирхолтойгоор тэмдэглэсэн байдаг.

Тэндээс 1801 онд 43 настайдаа⁷ нутаг хошуундаа буцаж ирэхэд хошууны тамгын газраас өөрийн хошуунаас төрсөн анхны лхарамба хүн гэж хүндэтгэн утгаж Буяныг Аривтгагч сүмд багш ламын ёсоор хүндэтгэж залан суулгажээ. Түүний дараагаар хошууны Шашныг Бадруулагч хийдэд очиж зургаадугаар Далай ламын шарилд мөргөөд хуралд манж эд түгээн, дамжаа барьж номын барилдлагыг зохион ерөөл тавьжээ.

Мөн жилийн 9-р сарын 20-нд Буяныг Аривтгагч сүмээс хошуу тамгын газарт айлтган цогчин гэсгүйд томилсон байна. Тус хийдийн дэглэм журмыг сайжруулан шавь нарт ном заан, хувраг лам нарын сахилга дүрэмийг чангатгаж, хурал номын үйлст шинэ хувь нэмэр оруулан олонд сайшаагдсан байна.⁸

1802 оны хар нохой жилийн 9-р сарын шинийн нэгэнд Алшаа хошой чин ван Ванчинбалбарын тамгийн газраас Агваандандар лхарамбыг Буяныг Аривтгагч сүмийн цогчин дацангийн ламд дэвшүүлэн, цорж болгон өргөмжилсөн зарлигийн бичиг нь тус хошууны түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.⁹

1804 оны хөх хулгана жил Буяныг Аривтгагч сүмийн цанид дацанг Баянгол гэдэг газарт нүүлгэж шилжүүлэн, Буяныг Үндэслэгч сүмийг байгуулахад Агваандандар лхарамбыг тус сүмд суулгахаар болжээ. Хожим энэ сүм Зүүн Сүм¹⁰ гэж алдаршсан бөгөөд Төвд нэр нь Мипамчойлин гэдэг байна. Тус сүмд очоод Цанид дацангийн тэргүүн ламд өргөмжлөгдөн сууж, хурал номын хэргийг ерөнхийлөн захирч байжээ.

Алшаа Агваандандар лхарамбын тухай аман домог ярианы зүйлүүдийн эмхтгэл

¹ Мөн Баруун багшийн яарианаас авав.

² Lha Idan smon lam rab 'byams pa

³ Smon rams pa

⁴ Lha Idan grwa skor pa'i ming can

⁵ Mkhas grub chos rjes mdzad pa'i rje bdag nyid chen po'i bstod pa dad pa'i rol mtso zhes bya ba'i 'grel pa dad pa'i rol mtsor 'jug pa'i gru gzings (30b талд)

⁶ Skya bas su 'gro ba'i tsul las brtams pa'i gnam 'dod dgu 'jo ba'i rin chen bum bzang (106b талд)

⁷ Зарим судлаачид 42 настайдаа гэсэн байна (Чоймбол, Ван Мандаа 1999)

⁸ Töbjirgal, Ayvandandar-un amidural ba jokiyal butegel-ün tuqai, Ayvandandar-un sudulyan-u ögülel-ün čiyulyan, Ayvandandar-un sudulul-un čubural bičig, Obör Mongyol-un soyol-un keblel-ün qorly-a, Qayilar Qota, 1999 (46-р хуудас)

⁹ ibid (46-р хуудас)

¹⁰ “Зүүн хийд нь их лам Алшаа Дандарлхарамбаас уламжилсан шашин номын тогтсон жаяг журмаараа нийтэд алдаршсан”. Козлов П.К. Монголия и Амдо и мертвый город Хора-хото, Москва-Ленинград, 1928

Агваандандар лхарамбыг Алшаа Зүүн сүмд байх зуур Лондол ламаас өөрийн шавь Хүүхэн хутагт Агваанлуvsанданзанравсал¹ Алшаад саатахаар очих тул түүнд туслахыг гуйсан захидал иржээ. Тэр захидалыг үзээд урьд багшийнхаа захиж байсан цаг ирэв гэж сэтгээд хутагтийг эрж сурахаар болжээ. Одоогийн Алшаа Зүүн хошууны хуучин Сүмтийн багийн Гүн худгийн голд байгаа Сүмтийн агуйд очиж Хүүхэн хутагт ламд золгож тарнийн номын авшиг лүн авсан гэдэг аман түүх байдаг.² Агуйд очтол нэгэн хар эмгэнтэй, архи дарс уудаг уудаг завхай дүртэй лам байхийг үзээд баахан дургүйцэж үл тоомсорлосон боловч багшийнхаа зарлигийг урвуулах аргагүй тул хадаг өргөн учир байдлаа айлтгахад хариуд нь хүний гавалын ясанд хийсэн хар архи өгч уулгах гэхэд нь дургүйцэн “Би гэлэн сахилтай хувраг билээ. Архи дарс огоот цээрлэх ёстой” гэж санатал тэрхүү гавал дахь архи нь аяндаа гал ноцож буцлахад. Надад илэрхий хувилгааныг бодитой үзүүлж байгаа юм байна гээд сүсэглэн архийг авч уужээ. Тэндээс Агваандандар лхаарамба Хүүхэн хутагттай номын барилдлага тогтоож, авшиг ном хүртэж, багш шавийн барилдлагатай болжээ.

Дээр өгүүлсэн Агваандандар лхарамба хийгээд Хүүхэн хутагт Агваанлуvsанданзанравсал хоёрын уулзалтын тухай эрдэмтэн Төвжаргалын бичсэнтэй төстэй өөр нэгэн түүх Л.Хүрэлбаатарын “Огторгуйн цагаан гарьд” (1996) номын Ноён хутагтын намтарын хэсэгт байдаг. 1983 оны хавар Дорноговь аймгийн Өргөн сумын Доржийн Лувсандорж гэдэг хүний ярьсан уг түүхээр бол Агваандандар лхарамба Ноён хутагттай 1831 оны туулай жил Гүнбүм, Лаврангаар ороод буцах замдаа Алшаа вангийн нутагт Эрвээхэй ууланд өвөлжиж байхдаа Агваандандартай уулзаж байсан гэж он цагийг тодорхойлон бичсэн байгаа боловч үүнийг цаашид нарийвчлан судлуустай байна.

Түүнчлэн Гандантэгчэнлин хийдийн унзад асан Дорноговь аймгийн Сайхандулаан сумын харьяат Мөнгөний Нацагдорж гуайн хуучилсанаар нэгэн удаа Алшаад буг босоод дарагдахгүй болсонд газар газрын олон мэргэдэд айлтгаж, мөн Халх Богдод айлтгахад Говийн согтуугаар даруул гэсэн байна. Тиймээс Алшаа ван Ноён хутагтыг залсанаар Ноён хутагт тэмээн жуузанд сууж, Дадишуара, Буяндэлгэр, Онгон Цогцоон Халиут зэрэг хандуудаа дагуулан, тэмээнд олон миглүүтэй архи ачиж, мөн унзад Да-Од Шонүгаа дагуулан аялж, Алшаа нутгийн захад очоод их найр хурим хийж байгаа нь Алшаа вангийн сонорт хүрэхэд ван өөрийн багш Дандар лхарамбад айлтган та очиж уулзаад нэг багцаа мэдэж ирээч гэж гуйжээ. Дандар лхарамба очоод “Танай хувилгаан багш хаана байна” гэхэд бүгд залбирсан гараараа зааж байсан гэдэг. Чингисийн хүрээгээр буудаллаж, голд нь хөлтрөгтэй жижиг өргөөнд сууж байхад нь ороод амгаланг айлтгаад суухад Ламрим чэмуун *ийнай лхагантинг* /Их бодь мөрийн зэргийн Амирлан ахуй хийгээд Үлэмж үзэхүйн тухай хэсэг/ дэлгэчихсэн, 16 орчим насны бүсгүйгээр үйлчлүүлэн халамцуухан сууж байжээ. Агваандандар асууж, “Танги чир он” /Юуны тулд ирэв/ гэж. “Срэй нан чир он” /Буг дарахаар ирсэн/ гэж Ноён хутагт хариулжээ. Тэгэнгүүт Агваандандар эргүүлээд “Срэй ган-на ёд ган гис ган-дү сад” /Буг хаана байдаг юм. Юугаар яаж дардаг юм/ гэж асуухад хутагт хариуд нь мөн төвдөөр “Срэй ар-зин түл-ви ор-ёд, донба-ниджи ан-ла дэ догвий шэй-рав-жи рал-ди дэ-еис нан” /Чөтгөр “би”-д барьсан эндүүрлийн талд байдаг. Хоосон чанарыг оносоны агаарт түүнийг оносон билгүүний илдээр намнадаг юм/ гэж хариулаад дамараа товшиход нь нэгэн шавь нь орж ирээд нэгэн боодолтой зүйлийг Ноён хутагтад өгчээ.Тэгээд Дандар лхарамбад өмнөө байсан нанчидаас барихад гэлэн хүн учир уухгүй гэсэн боловч амсаад өгчээ. Боодолтой зүйлээ өгөхөд нь залбираад авсан гэдэг. Тэр боодолтой зүйл нь үзэхэд дотор нь дүнсэн тамхи байсан бөгөөд *агжий ойдувжи зай*

¹ Бусад аман ярианд Хүүхэн хутагтыг Говийн догшин ноён хутагт Агваанлуvsанданзанравжаа гэж гардаг.
² Tobjirgal, Ayvandandar-un amidural ba jokiyal butegel-un tuqai, Ayvandandar-un sudulyan-u ogüel-un ciyulyan, Ayvandandar-un sudulul-un cübural biçig, Obör Mongyol-un soyol-un keblel-un qoriy-a, Qayilar Qota, 1999 (49-p хуудас)

/тарнийн шид бүтээлийн зүйл/ байжээ. Тэндээс Агваандандар гарч, Алшаа ванд "Сайн хүн бол Сажүви жанчүв сэмбээс /арван газарын бодисадва/ наашгүй сайн хүн байна. Саар хүн бол Дүдгарванчүгээс /шуламын хаан/ доошгүй муу хүн байна. Би л лав шавь орчихлоо" гэж хэлсэн гэдэг. Бас иймэрхүү хууч яриаг төвдөч Чулууны Алтангэрэл агсан 1968 онд хэвлүүлсэн "Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээлийнхээ" II дэвтэрт, Равжаа хутагтын төвдөөр бичсэн шүлгийн тухайд холбогдуулан өгүүлэхдээ тэмдэглэж бичсэн нь бий.

Мөн Нацагдорж гуайн ярьсанаар бол Дандар лхарамбыг Лхасад дамжаа барьсаныхаа дараа багшдаа бараалхахад Лондол лам жишимгүй байж, "Чи хоноггүй яв, унаа хөсгийг чинь бэлдсэн, чамд нэг анхааруулах юм байна. Дор газраас налжорва маягтай хүн ирнэ. Уулзчихвал үйлс чинь дэлгэрнэ шүү" гэсэн гэдэг бөгөөд тэр хүн нь Ноён хутагт байсан байна.¹

Мөн Гандангийн Идгаачойнзин дацангийн шунлайв асан Доржжанцан гуайн ярьснаар Төвдөд хамгийн олон боть зохиол бичсэн хүн бол Бодон Чоглайнамжал. 108 боть зохиол бичсэн, Янжинлхам бурхан шалсигласан хүн байсан. Монголд хамгийн олон зохиол бичсэн хүн бол Дандар лхарамба байсан. *Чагбри* /гар бичмэл/ нь нэг байсан түүрч байсан гэдэг. Алшаа ван Бээжинд явахдаа багшийгаа авч явах үеэр хулгайч ирээд авах юм байхгүй болохоор нь уурлаад шатаачихсан гэж ярьдаг. Түүнээс хоёрхон боть үлдсэн гэдэг.

Сонинбаяр ламын ярьснаар бол Нансрид лхарамба Баруун Зуу орох замдаа Дандар лхарамбатай уулзахаар сураглан очиж уулзахаар ороход нэгэн жодгор дотор гаансандаа тамхи нэрчихсэн сууж байжээ. Энэ нь бол угтаа *пройжсай*² *шиндү проймэдэжий*³ бясалгалын үедээ сууж байсан ажээ. Энэ үед Нансрид лхарамба "дондамбар мэд гүнзовдү ёд" /алив юмс үнэмлэхүйд хоосон чанартай гэх янагуухд үнэхээр орших гэх / гэдэг чинь ер нь ямаршуухан юм байх юм гэж асуухад нь "дондамбар мэд" гэдэг нь энэ гээд баганан дундуураа гаансаа торолтгүй гаргаад, "гүнзовдү ёд" гэдэг нь энэ юмдаа гээд жодгорынхоо цоорхойгоор туссан нарны гэрэл дээр гаансныхаа уутыг тохож үзүүлж байжээ. Нансрид лхарамба Баруун Зууд ном үзээд буцахдаа Дандар лхарамбынхаар дайрч уулзахад нь одоо Лхасад хэн ангилаж байна гэхэд нэрийг нь хэлэхэд шашин их л доройтож дээ "жорлам дод"⁴ л товлосон хүн дээ гэж байсан гэдэг.

Агваандандар сахилаа өргөж хар болоод Юнгүнмаа⁵ гэдэг эмэгтэйтэй сууж, эгэл хүний ёсоор ямаа маллан амьдардаг байсан гэдэг. Түүний эхнэрийг эгэл жирийн хүнтэй адилгүй нэгэн байсан гэдэг аман яриа олны дунд байдаг бөгөөд харахад хамаргүй хар чавганц байсан гэдэг боловч үнэн хэрэгтээ ханд дагинасын хувилгаан байсан гэж ярьцгаадаг. Юнгүнмаагийн зохиосон Улаан Дара эхийн уншлагын судар Алшаагийн Буяныг Аривтгагч сүмд байдаг байна.⁶

51 настай байх үедээ Амдогийн Гүмбүм, Гонлүн зэрэг олон хийдүүдээр тойрон, зохист аялгуу, дуун ухааны номыг гүйцэд сурахаар явах зуураа Гүмбүм хийдэд нэлээн

¹ Сонинбаяр гавьжтай хийсэн ярилцлага.

² Дээд үгүй егүзэрийн ёсоор үүсгэл төгсгөлийн хоёр зэрэгт суралцаж буй егүзэрийн аргын явдал мөр.Дотоод сэтгэлийн гүн төвлөрөлд оршин амгалан хоосныг найралдуулах дор голлон үйлдэх бясалгалын үйл болой.

³ Дээд үгүй егүзэрийн ёсоор үүсгэл төгсгөлийн хоёр зэрэгт суралцаж буй егүзэрийн аргын явдал мөр.Хослон орохуйг төгсгөн төгсгөн гадна талдаа хооллох,бие засах,унтах төдийг үйлдэн голлон нойрны гэгээн гэрэл ямагтыг анхааран бясалгах егүзэрийн явдал үйл.

⁴ Судрын ёсоор бурханы хутагыг олох таван мөрийн хоёрдугаар мөр буюу найруулахуйн мөрийн доторх дөрвөн зэрэг буйн анхдугаар үе шат

⁵ Töbjirgal, Ayvandandar-un amidural ba jokiyal butegel-ün tuqai, Ayvandandar-un sudulyan-u ögülel-ün čiyulyan, Ayvandandar-un sudulul-un čubural bičig, Obör Mongyol-un soyol-un keblel-ün qoriy-a, Qayilar Qota, 1999 (49-p хуудас)

⁶ Töbjirgal, Ayvandandar-un amidural ba jokiyal butegel-ün tuqai, Ayvandandar-un sudulyan-u ögülel-ün čiyulyan, Ayvandandar-un sudulul-un čubural bičig, Obör Mongyol-un soyol-un keblel-ün qoriy-a, Qayilar Qota, 1999 (49-p хуудас)

удаан сууж, тэр талын бүтээлүүдийг сурч боловсорсон боловч үр бүтээл муухан байсан учир Лавран Дашчил хийдэд очиж, тэндэхийн зохист аялгуу хийгээд дуун ухааны алдартай эрдэмтэн багш дооромбо Лхаше гэдэг ламд шавь орон, гэрт нь нэрээ нууцлан сууж, зохист аялгууны ном заалгаж байх зуур тэр ламын нэгэн бага шавь нь чойрт дамжаа барихаар бэлтгэж байхад нь Агваандандар лхарамба тусалснаар олон шавь нарын дотор тэргүүлж түрүүлжээ. Үүнд тус хийдийн олон мэргэд багш нар гайхаж, ийм гайхамшигтай оновчтой сайхнаар дамжаа барьж байсан шавь гарч байсан түүх цөөхөн тул гаднаас хүн магад тусалсан байх гэж сэжиглэн туршиж мэдэхээр тэр бандийн нөхөрлөдөг өөр нэгэн бандиар туршуулснаар Алшаагийн Агваандандар лхарамба нэрээ буруулан тус хийдэд ирээд сууж байгааг мэдэж, өргөл хүндлэл үйлдэн ном айлдахыг гуйснаар ном үзэхэд нь саад барчад гарчээ гэдэг. Тэндээс сэм зугтаж Хамын Дэргэ¹ хийдийн Ригнай дацанд орж, дуун ухааны номыг үзэж дүүрэгсэн байна.² Түүнчлэн төвд хэл бичгийн ухааныг нэвтэрхий сурсаныхаа дараа Монголын олон газруудаар аялан явж монгол хэл бичгийг гүнзгийрүүлэн сурч, Төвд Монгол дохионы бичиг болон монгол хэл зүйн бүтээлүүдээ туурвисан гэдэг. Дээрхи яруу найраг сурсан тухай түүхтэй холбоотой нэгэн мэдээлэл түүний өөрийн зохиол *Зохист аялгууны толийн гуравдугаар бүлгийн үлгэрлэн өгүүлсэн саруул оюунтны хоолойн чимэг үзэсгэлэнт сувдан эрхи хэмээхэд* нь тэмдэглэгдэн үлдсэн байдаг бөгөөд уг зохиолд "...би өөрөө хар аяндаа шүлэг бичих сонирхол их хэдий ч зохист аялгууг эс мэдэх учир аргаа бараад сурахыг хүсэн багшийг эрж хайваас До-мадын Гүнбүм, Гонлүн хийдүүдэд уламжлалт сургалтаар боловсорсон мэргэд байхгүйн дээр Доод Төвдийн зүгт ч байхгүй сурагтай тул сэтгэлийнхээ угаас харамсаж, зохист аялгууны уламжлал тасрах нь гэж бодоод тавин нэгэн настайдаа бэрхшээлийн хайхралгүй Лавран Дашчил хийдэд хүрч Доорамба Лхашегийн дэргэдээс Хам Дэргэгээс дамжсан уламжлалын дагуу *Эгшиглэнт эхийг баясгагч дууны* анхдугаар бүлгээс эхлээд гутгаар бүлгийн Нууц үгийг хүртэл шүүлэг өгөн дуустал нь сурч гүйцээгээд нутагтаа буцаж ирээд ч *заваа дэлбийг* /үндэс тайлбар/ хавсарган дахин дахин үзэж бусад мэргэдийн сайн номлолуудад ч ижилдүүлэн үйлдэж..." гэж бичсэн байна.³ Тэндээс нутагтаа буцаж ирснийхээ дараа Халхын Говь Түшээ гүний хошуу, Долоннуур, Утай, Ширээт Зуу, Бээжин тэргүүтэн олон газараар бадарчлан явж олон газрын эрдэмтэн мэргэдтэй уулзаж, ном хэлэлцэж, ном айлдаж явсан гэдэг. Энд дурьдахад Төвжаргалын бичсэн Агваандандар лхарамбын намтарт (1999: 52) түүнийг Их Хүрээнд байхдаа Шижээ гавьжид шавь орж байсан гэж бичсэн байдаг нь Агваандандар лхарамбийг Шижээ гавж Агваандондовын шавь Ханд чин вангийн хошууны Дандар аграмбатай андуурсан бололтой юм. Халхын Говь Түшээ вангийн хошуунаас буцан Өвөр Монголын нутагаар бадарчлан явахдаа Түмэд Баруун гарын Бадгар Зуу хийдэд тус хийдийн гэгээн Дүйнхэр бандида хутагт Рашнямын заллагаар нэг жил шахам саатан, тэндхийн Чойр дацангийн багш болж, хийдийн шавь нарт ном зааж байжээ.

Бээжингийн Юнхэгүн сүмд очиж сүмийн хуврагуудад ном зааж байх зуураа цайны тухай судалгаа хийж цайны уг гарал тэргүүтний тухай тайлбарласан "Цайны тухай тайлбар" хэмээх номоо зохиосон гэж уг номын төгсгөлийн үгэнд байдаг.

Ийн явсаар 1829 онд 71 настайдаа Алшаад буцаж ирээд Буяныг Үндэслэгч сүмд сууж, туурвил бүтээлээ хийсээр насан эцэслэх хүртлээ тэндээ суусан ажээ.

¹ Төвдийн зүүн хэсгийн нутагийг Хам гэдэг бөгөөд Дэргэ хийд нь одоогийн БНХАУ-ын Сычуан мужийн Төвдийн өөртөө засах засах Гарзе хошууны нутагт байдаг.

² Töbjirgal, Ayvandandar-un amidural ba jokiyal butegel-ün tuqai, Ayvandandar-un sudulyan-u ögulel-ün cüyulan, Ayvandandar-un sudulul-un cübural bičig, Obör Mongyol-un soyol-un keblel-un qoriy-a, Qayilar Qota 1999 (49-p хуудас)

Энэ түүх Төвд лам нарын дунд мөн яригдаж байдаг.

³ Snyan ngag me long le'u gsum gyi dperbjod blo gsal mgul rgyan mu tig phreng mdzes (34a-34b талд)

Агваандандар лхарамбын чухам хэдийд таалал болсон он цагийн тухайд судлаачид нилээд зөрүүтэй бичсэн байдаг. Агваандандарын “Долоон утгат оюун судлахуйн чухал хэрэгтэй үг их хөлгөний дөт зам” хэмээх зохиолын төгсгөлийн үгэнд “81 сүүдэртэйдээ арван дөрөвдүгээр жарны шороон гахай жил зохиов” гэж бичснээс үзвэл 1839 онд сэрүүн тунгалаг зохиол бүтээлээ туурвиж байсан байжээ.

Ван Мандаугагийн бичсэн *Агваандандар ба түүний намтар бүтээл*¹ гэдэг өгүүлэлд өгүлсэнээр Буяныг үндэслэгч сүмийн түүхийн эвхмэл бичигт “Агваандандар нь 82 настай, Төр гэрэлтийн 2-р оны өвлийн дунд сарын арваны буянт өдөр амирлангуйгаар нирваан дүрийг үзүүлвэй.” гэж тэмдэглэсэн байдаг гэсэн мэдээ байна. Түүнчлэн Өвөр Монголын эрдэмтэн Ө.Мандах “Чин улсын Төр гэрэлтийн хорьдугаар онд (1840) одоогийн Алшаа Зүүн хошууны Мөрөн гол суманд (Алшаа аймгийн Баянгол) нас барав. Агваандандар энэ ертөнцийн 82 хавар намрыг өнгөрүүлсэн аж.” гэж түүнийг яг хэдийд хэдэн настайдаа таалал болсон талаар нилээд тодорхой баримттай өгүүлсэн байдаг². Энэ бүхнээс үзвэл Агваандандар лхарамба 1840 онд таалал болсон байна. Мөн 1957 оны үеэс Алшаа нутгаар Агваандандарыг тухайлан сурвалжилсан Өвөр Монголын судлаач Б.Сэцэн, Ш.Далантай нар “түүний хөрөг гэж бурхан шиг зурсан тост зураг байлаа. Хөрөг... доод талд lha-ldan-smon-lam-rab’ byams-ra-ngag-dbang-btsan-dag гэж бичсэн байна. Тэр зураг ба тус хийдийн уулан дээр байсан булшийг бид нар гэрэл зурагт буулгаж авлаа” гэсэн нь Агваандандарыг хаана оршуулсаныг мэдээлж байна.

Агваандандар лхарамбын нэгэн насны амьдралын намтар зохиолыг үзвээс өөрийн бүхэл амьдралыг эрдэм номын үйл хэрэгт зориулсан бурханы шашны хувраг хүний амьдрал мэт боловч нөгөө талаар шашны эрдэм номын хамгийн дээд оргилд хүрсэн ч нууц тарнийн ёсоор эгэл жирийн нэгэн малчин өвгөний дүрээр ч байж, бас элдэв газар орноор хэрэн явж эрдэмт мэргэдтэй уулзан, ном хэлцэж, улам улам суралцахуйд шамдан, газар газрын олон сүм хийдүүдийн хувраг шавь нарт ч эрдэм номын өглөг түгээхийн сацуу зохион туурвих их үйлийг нэн шамдсан байдаг бөгөөд бурханы шашны эрдэмтэн мэргэдийн нэгэн адилаар номлох, хэлцэх, туурвих гурван аргаар замнасны эцэст сонсох, санах, бясалгах туйлд хүрсэн агуу эрдэмтэн болсон ажээ. Түүний амьдралын онцлог тал нь Төвд, Монголд нэр алдар нь дуурьссан их эрдэмтэн мэргэн болсон боловч сүм хийдийн газар зэрэг дэв мяндаг тушаалд баригдан суусангүй, орчлонгийн хуран үймцээнээс дайжин үнэтэй зохиол бүтээлээ туурвиж хойч үеийнхэндээ үлдээсэн ачтан билээ. Агваандандар лхарамбын намтараас үзвэл хожмоо Гаадамбын ёсны дээдэс Бором Донбын гэгээн тэргүүтэн адил энэ насыг оюунаараа орхин гүн гүнзгий бясалгалын зэрэгт сришиж, аглаг зэлүүд агар модот Алшаагийн уулнаа даяанчийн дүр байдлыг барин жинхэнэ бурханы хутагыг зорьсон дээдсийн явдалаар амьдарч байсан байна.

Хуучцуулын ярианд “Лондол явсрайн сүнбүмийн лүнг хүртэхэд Шамбалын оронд бэрэлба шагалдаг хэмээн ярьдаг”³. Энд Лондол явсрай гэдэг нь төвдөөр Лондол эцэг хүү гэсэн утгатай бөгөөд энд Лондол лам Агваанлуvsан болон Агваандандар лхарамба багш шавь хоёрыг хэлж байгаа бөгөөд энэ хоёр ламын бүрэн зохиолын аман эшийн дамжлагыг сонсож хүртэх юм бол ирээдүйд Шамбалын оронд төрөх номын барилдлагыг тогтооно гэсэн утгатай ажээ.

Агваандандар Лхаарамбын зохиол бүтээлийн тухай

¹ Ayvandandar-un sudulyan-u ögülei-ün ciyülyan, Ayvandandar-un sudulul-un çubural biçig, Obör Mongyol-un soyol-un keblel-ün qoriy-a, Qayilar Qota, 1999 (67-р хуудас)

² Ibid. (155-р хуудас)

³ Гандантэгчэнлин хийдийн Эрдэм соёлын хүрээлэнгийн захирал гавьж Ш. Сонинбаярт гавьж тэргүүтэнд Данзан-Осор, Иштавхай зэрэг эрдэмтэй лам нар уг хийдийн Номын гэрт номын нийллэгэн дээр ярьж байсан байна. 2009 оны 5 сарын 25-нд Гандантэгчэнлин хийдийн Эрдэм соёлын хүрээлэнд хийсэн ярилцлага.

Алшаагийн Агваандандар лхарамба Буддын гүн ухааны арван дөрөв, хэл шинжлэлийн хамаатай зургаа, яруу найргийн онолоор зургаа, шашны зан үйлийн холбогдолтой долоо, элдэв захиа бичиг тэмдэглэлээр гурав тэргүүтэн нийт гучин зургаан бүтээл тууригдсан нь хоёр ботиор Амдогийн Гүнбүм хийдэд хэвлэгдсэн байдаг. Үүнээс гадна түүний сүнбүмийн эмхтгэлд орж хэвлэгдээгүй “Нэр утгийг тодотгогч саран гэрэл” хэмээх төвд монгол хэлний толь бичиг, “Монгол үсгийн ёсыг сайтар номлосон хэлний чимэг” хэмээх монгол хэлзүйн бичиг хоёрыг нэмбэл гучин найман зүйл зохиол болно. Ихэнх зохиолоо Алшаагийн Буяныг Аривтгагч сүмд сууж байхдаа тууригдсан гэдэг. (Төвжаргал 1999: 63)

Агваандандарын бүрэн зохиолын эмхтгэл

Агваандандар ихэнх зохиол бүтээлээ тэр үеийн эрдэмтэн мэргэдийн нэгэн адил тухайн цагийн Бурханы шашинт эрдэмтдийн эрдэм шинжилгээний гол хэл болж байсан төвд хэлээр бичсэн байдаг. XIX зууны дунд үед түүний зохиолын бүрэн түүвэр “Алшаа лхарамба Агваандандарын сүнбүм” гэсэн нэртэйгээр нийтдээ 775 хуудас судрыг Хөх нуур дахь Амдогийн шашин номын гол төв хүрээлэн болох Гүнбум хийдийн барханд хэвлэгдэн гарсан байдаг. Түүнчлэн 1982 онд энэтхэгийн нийслэл Дели хотод “Collected Works of Ngag dbang bstan dar” гэсэн нэртэйгээр Монгол лам Гүрүдева хэвлүүлсэн байна. Эдгээр сүнбүмүүдийн хувь нь Улсын Төв Номын Сан болон Гандантэгчэнлин хийдийн номын санд хадгалагдаж буй, түүний төрсөн нутаг Алшаад нилээд судалгаа хийгдэж, Алшаа зүүн хошууны хэл бичгийн ажлын зөвлөлийн Хэ. Чоймбол Агваандандарын сүнбүмийн гарчигийг орчуулан “Баян Сүмбэр” сэтгүүлийн 1991 оны 2-р дугаарт нийтлүүлжээ. Чоймбол түүний сүнбүм дэхь зохиолуудыг Гүн ухаан, Хэл шинжлэл, Яруу найраг гэсэн гурван үндсэн бүлэгт хуваан авч үзсэн байдаг. Алшаа аймгийн Монгол эм эмнэлэг судлах газрийн Пан Норов гуай “Алшаа Агваандандарын домгийн намтар” гэсэн өгүүлэлийг 1990 оны Алшаа хэл сэтгүүлийн 4 дэхь дугаарт нийтлүүлж түүний сүнбүмийн гарчигийг орчуулсан зохиол бүтээлийн нэрсийг жагсаан нийтэлсэн байдаг. Гандантэгчэнлин хийдийн лам Р. Бямбаа Агваандандарын сүнбүмийн гарчигийг орчин үеийн ном зүйн бүртгэл маягаар судлан, түүний сүнбүм болон, сүнбүмд ороогүй зохиол бүтээлүүдийн бүрэн гарчигийг хэвлүүлсэн байдаг.

Алшаа Агваандандар лхарамбын сүнбүм дэхь номуудыг үзвэл түүний зохиол бүтээлд гүн ухаан онол сэтгэлгээ, уран зохиол яруу найрагын онол, төвд хэлний зүй болон сургаал шүлгүүд гол байр суурийг эзлэх бөгөөд элдэв зүйлийн мэргэ төлөг, гүрэм засал, шашны зан үйлийн талын ном зохиогоогүйгээрээ нилээд онцлогтой байдаг. Гүн ухааны талын зохиол нь түүний гүн ухаанд гарамгай сайн мэргэжсэнийг харуулах бөгөөд ухаж ойлгоход амаргүй, цанид чойрын номын өндөр мэдлэг, гүнзгий ухаарц шаардсан нягт, гүн, хурц, тод төгөлдөр бүтээлүүд болсон байдгаараа онцлог болно.

Агваандандарын Монгол хэл шинжлэлийн бүтээл хийгээд түүний судалгаа

Агваандандарийн зохиол бүтээлүүдээс түүний бичсэн монгол хэл шинжлэлийн талын бүтээл нь эрдэмтэн судлаач нарын сонирхлыг татаж, хамгийн өргөн хүрээтэйгээр судлагдсан байдаг. Ялангуяа түүний бичсэн “Монгол үсгийн ёсыг сайтар номлосон хэлний чимэг хэмээх оршвой” гэдэг бүтээл нь гар бичмэл хийгээд модон бараар өргөн тарсан байдаг бөгөөд урьд цагт монгол хэл сурах гол сурах бичгүүдийн нэг болж байсан билээ. Уг бүтээл нь Дайчин улсын үед Өвөр Монголд модон болон хорголжин бараар энд тэнд хэвлэгдсэнээс гадна Буриадын Дэчинлхүндэв хийдийн барханд модон бараар хэвлэгдсэн байдаг. “Хэлний чимэг”-ийн уг эхийг Өвөр Монголын “Монгол хэл бичиг” сэтгүүлийн

1957 оны 5 дахь дугаарт судлаач Сүнрэв нийтлүүлэн, түүний дараачийн 6 дахь дугаарт Б. Сэцэн, Ш. Далантай нар “Алшаагийн равжамба Агваандандарын “Хэлний чимэг”-ийн тухай гэсэн сэдэвтэй анхны судалгааны өгүүлийг хэвлүүлжээ. Мөн зохиолын эхийг 1959 онд Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос эрхлэн “Монгол хэлний шинжлэлийн дурсгал бичиг” хэмээх сурвалж бичгийн эмхтгэлд оруулан дахин хэвлэжээ. Тавиад оны эхээр манай эрдэмтэн Б. Ринчен, Ц. Дамдинсүрэн нар Агваандандар хийгээд түүний зохиосон “Хэлний чимэг”-ийн тухай анх удаа тойм төдий танилцуулсан байдаг. МУИС-ийн эрдэмтэн Ш. Чоймаа “Алшаа Агваандандар бол XVIII-XIX зууны нэрт хэл шинжлэлтэн мөн” (1995) гэдэг өгүүлэлдээ түүний хэлний шинжлэлийн талын бүтээлийг нилээд дорвитойгоор судалсан байдаг¹. Ер нь Агваандандарын “Хэлний чимэг” бол XIV зууны үед Чойжи-Одсэр бандидагийн зохиосон “Зүрхэн тольт”, түүний тайлбар гүүш Данзандагвын бичсэн “Огторгуйн маань” хэмээх монгол хэлний судлалын алдарт бүтээлүүдээс хойш гарсан хамгийн том бүтээл болно. Урьдах хоёр бүтээлд дурьдагдаагүй буюу цухас дурьдагдсан зүйлсийг цаашид гүнзгий судлан гаргаж, монгол бичгийн хэлний зөв бичих, зөв дуудах асуудлыг нарийн тодорхой тайлбарласны хувьд дараачийн үеийн монгол хэлний судлалд чухал нөлөө үзүүлсэн байна. (Сүнрэв 1999: 8-9)

Төвд Монгол толь бичгийн тухай

Агваандандарын хэл шинжлэлийн талын зохиол бүтээлийн дотор “Саран гэрэл” хэмээх төвд монгол толь бичиг чухал байр суурь эзэлдэг. Уг толь бичгийн төгсгөлийн үгэнд дурьданаар бол “Нэр утгыг тодотгогч Саран гэрэл хэмээх дохионы бичиг” хэмээн энэ зохиолоо өөрийнхөө 81 настай байхдаа зохиож дуусахад нь Алшаа хошууны захирагч занги Намуяа 70 лан цэвэр мөнгө хандивлан өргөж Бээжингийн Сүнжүсийн барханд анхлан хэвлүүлжээ. Түүнчлэн Буриадын Агийн дацан Дэчэнлхүндэвлинд хэвлэгдсэн байдаг бөгөөд Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос 1990 онд дэвтэрлэн хэвлэсэн байна. 10000 гаруй үг бүхий энэхүү толь бичиг нь төвд хэл эхлэн суралцагчдад гол ашиглах хэрэглэгдэхүүн болсоор байгаа нэн чухал бүтээлүүдийн нэг билээ.

Зарим судлаачид “Нарны гэрэл” гэдэг өөр нэгэн төвд монгол толь бичиг зохиосон байдаг гэдэг боловч одоо энэ толь бичиг олддоггүй бөгөөд түүний олон зохиол бүтээлийг галд өргөсөн гэсэн аман мэдээ ч байдаг тул үрэгдсэн байж болох юм. “Нарны гэрэл” гэдэг төвд хэлний дохионы бичиг байна гэж хүмүүс үзүүлдэгч энэ нь Төвдийн эрдэмтэн Борова равжамбагийн зохиолтой эндүүрэгдсэн байдаг байна. (Р.Бямбаа 2004: 507)

Энд дашрамд дурьдахад Гэлэгпэл хэмээх хүний монгол хэлээр зохиосон “Төгс цогт Хан Алшаагийн тахилга хүслийг түргэнээ хангагч чандмань” хэмээх номыг туслагч Намжалдоржийн дурьдсанаар Агваандандар төвд хэлэнд орчуулсан байдаг гэсэн мэдээ байна. (Сүнрэв 1999: 12)

Агваандандар Лхарамбын намтарт холбогдох харьцуулсан хүснэгт

Европын он	Монголын хуучин он	Төрийн он	Агваандандар Лхарамбын намтарт холбогдох зарим үйл явдал
1758	Шар бар	Тэнгэрийн тэтгэсэн 23	Зарим зохиол бүтээлд Агваандандар Лхарамбыг энэ онд төрсөн гэдэг
1759	Шарагчин туулай	24	Алшагийн Агваандандар Лхарамба төрөв (-1842) ²
1765	Хөхөгчин тахиа	30	Лам болж Алшаа хошууны Буяныг Аривтгагч сүмд шавилан суужээ ¹

¹ Ш.Чоймаа, Монгол хэл шинжлэл, 198-209 дахь тал

² Ц. Дамдинсүрэн, Мянган жилийн харьцуулсан хүснэгт, эмхэтгэсэн Ц. Баярсайхан, 1995 он, 52 дахь тал

1777	Улаагчин тахиа	42	19 нас хүртлээ хийдийнхээ Цанид дацанд суралцсан ² Сүмба Хамбо (багш нь) "Замдин жишад" хэмээх газар зүйн номлолыг зохиов ³ Гонлүн хийдэд дээд монгол алдарт эрдэмтэн Сүмбэ Хамба Ишбалжорт шавь орж 1 жил шахам ном заалгажээ ⁴ 19 настайдаа Амдогийн Гонлүн болон Гүмбум хийдүүдээр дамжин Төвд орохоор явжээ ⁵
1778-1780 орчим	Шар нохой	43	Бэрээвэн хийдийн Гомон дацанд очиж Лондол лам Агваанлуvsан (1719-1805) -д шавь орж гэлэн сахил хүртэн сахилын нэр нь Агвандандар болсон байна ⁶
1786	Улаан морь	51	II Жанжаа хутагт Ролбийдорж (багш нь) нас барав (1717-) ⁷
1788	Шар бич	53	Сүмбэ Хамба Ишбалжир нас барав (1704-) ⁸
1801 он хүртэл	Цагаагчин тахиа	Сайшаалт ерөөлт 6	43 настайдаа нутаг хошуундаа буцаж ирж Буяныг Ариvтгагч сүмд залагджээ
1802	Хар нохой	7	Хошууны түүхэнд тэмдэглэснээр Алшаа хошой чин ван Банчинбалбарын тамгын газраас Буяныг Ариvтгагч сүмийн цогчингийн Цорж болгон өргөмжилсөн зарлиг гарчээ
1803	Харагчин гахай	8	Шүлэгч V ноён хутагт Равжаа төрөв (1803-1856) ⁹
1804	Хөх хулгана жил	9	Буяныг Ариvтгагч сүмийн Цанид дацанг Баянгол гэдэг газарт нүүлгэн шилжүүлэхэд Агвандандар Лхарамбыг тус дацанд суулгахар болжээ. Хожим нь энэ сүм Алшаагийн Зүүн сүм гэж алдаршсан байна
1828	Шар хулгана	Төр гэрэлтийн 8	"Хэлний чимэг"-ийг зохиов ¹⁰
1829	Шарагчин үхэр	9	71 настайдаа "Зохист аялгууны толийн III бүлгийн жишээ шүлэг- үзэсгэлэнт сувдан эрхи"-ийг зохиожээ ¹¹
1830	Цагаан бар	10	"Хүмүүний номын баяр хурим" хэмээх алдарт сургаалиа номлож, "Адистидийг урих яруу эгшгийн цэнгэл" номоо туурвижээ ¹²
1831	Цагаагчин туулай	11	Равжаа Алшаад очиж Агвандандар хэмээх Лхас зуугийн их Лхарамбатай уулзсан, бие биедээ багш шавь болсон... ¹³ Равжаа Гүмбум, Лаврангаар ороод туулай жилийн зун Алшаа вангийн нутагт очиж "Саран хөхөө" жүжгийг

¹ Coγtu. G., Ayvандандар-un tobci namtar ba tegн-ь jokial бьteгel. Ayvандандар-un sudulal-un цбylel-ьн cigulγan. Ayvандандар-un sudulal-un cubural bicig. Цбцr Монγol-un soyol-un keblel-ьн qoriy-a. Kцke qota. 1999. хуудас 79-84.

² ibid

³ Ц. Дамдинсүрэн, Мянган жилийн харьцуулсан хүснэгт, эмхэтгэсэн Ц. Баярсайхан, 1995 он, 54 дахь тал

⁴ Tobjirγal. Ayvандандар-un amidural ba jokial бьteгel-ьн tuqai. Ayvандандар-un sudulal-un цбylel-ьн cigulγan. Ayvандандар-un sudulal-un cubural bicig. Цбцr Монγol-un soyol-un keblel-ьн qoriy-a. Kцke qota. 1999. хуудас 35-67.

⁵ ibid

⁶ Tцbjirγal. Ayvандандар-un amidural ba jokial бьteгel-ьн tuqai. Ayvандандар-un sudulal-un цбylel-ьн cigulγan. Ayvандандар-un sudulal-un cubural bicig. Цбцr Монγol-un soyol-un keblel-ьн qoriy-a. Kцke qota. 1999. хуудас 35-67.

⁷ Ц. Дамдинсүрэн, Мянган жилийн харьцуулсан хүснэгт, эмхэтгэсэн Ц. Баярсайхан, 1995 он, 55 дахь тал

⁸ ibid 55 дахь тал

⁹ Ц. Дамдинсүрэн, Мянган жилийн харьцуулсан хүснэгт, эмхэтгэсэн Ц. Баярсайхан, 1995 он, 57 дахь тал

¹⁰ ibid 58 дахь тал

¹¹ Л. Хүрэлбаатар, Огторгуйн цагаан гарди, 1996 он, 151 дахь тал

¹² Bslab bya m chos dga'ston 9A тал

¹³ Л. Хүрэлбаатар, Огторгуйн цагаан гарди, 1996 он, 150 дахь тал

			залж авчирсан. Энэ үед Агвандандарын сорилт ирсэн ¹
1832	Хар луу	12	Шүлэгч Равжаа (1803-1856) "Саран хөхөөний намтар" хэмээх дуурийг дэглэж тоглуулав ² "Луу жил Говийн ноён хутагтын өгсөн захианы хариу" хэмээхийг бичив ³
1835	Хөхөгчин хонь	15	77 настайдаа "Дарь эхийн магтаал мэргэдийн зулайн чимгийн тийн номлол"-оо бичжээ ⁴
1838	Шар нохой	18	Төвд монгол толь "Сарны гэрэл"-ийг зохиов ⁵
1839	Шарагчин гахай	19	81 настайдаа "Долоон утгат оюун судлахуйн чухал хэрэгтэй үг их хөлөгний дөт зам" хэмээх зохиолоо бичжээ ⁶
1840	Цагаан хулгана	20	80 настайдаа (1840) "Сарны гэрэл" хэмээх алдарт төвд монгол дохионы бичгээ зохиожээ ⁷ Чин улсын Төр гэрэлтийн 20 дугаар онд (1840) одоогийн Алшаа зүүн хошууны Мөрөн гол суманд нас барав ⁸
1841	Цагаагчин үхэр	21	Үхэр жилийн (1841) цагаан сараар Алшаагийн баруун хийдээс цааш явахыг завдтал бас Жанжаа гэгээнээс буцаасан... ⁹
1842	Хар бар	22	Алшаагийн Агвандандар Лхарамба (1759-) нас барав ¹⁰

¹ Ibid 149 дэх тал

² Ц. Дамдинсүрэн, Мянган жилийн харьцуулсан хүснэгт, эмхэтгэсэн Ц. Баярсайхан, 1995 он, 59 дэх тал

³ Brug lor gho ba'i no yon hu thug thus bstzal ba'i gsung lan, 10Б - 11А,Б тал

⁴ Л. Хүрэлбаатар, Отгоргуйн цагаан гарди, 1996 он, 151 дахь тал

⁵ Ц. Дамдинсүрэн, Мянган жилийн харьцуулсан хүснэгт, эмхэтгэсэн Ц. Баярсайхан, 1995 он, 59 дэх тал

⁶ Bio sbyong don bdun ma la nye bar mkho ba'i gtam theg mchog nye lam zhes bya ba

⁷ Л. Хүрэлбаатар, Отгоргуйн цагаан гарди, 1996 он, 151 дахь тал

⁸ Manduy-a, Wang. Ayvандандар ba tegьн-ь namtar byegel. Ayvандандар-un sudulal-un цыгел-ьн cigulyan. Ayvандандар-un sudulal-un cubural bicig. obor Монгол-un soyol-un keblel-ьн qoriy-a. Koke qota. 1999. хуудас 67-79.

⁹ "V Ноён гэгээнтний цадигийн товч хураангуй"

¹⁰ Ц. Дамдинсүрэн, Мянган жилийн харьцуулсан хүснэгт, эмхэтгэсэн Ц. Баярсайхан, 1995 он, 60 дахь тал